



/АМГТГ-ын даргын 2018 оны А/73 дугаар тушаалаар хүчингүй болсон/

АМХЭГ-ын даргын 2001 оны 133  
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**ТӨРИЙН НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛД ОРСОН 1:100000-НЫ МАСШТАБЫН БАЙР ЗҮЙН  
ЗУРАГТАЙ ХАРЬЦАХ БОЛОН ТАНИЛЦАХ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, АЖИЛЛАГСДАД ҮЙЛЧЛЭХ  
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигийн дагуу Монгол Улсын төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглахад энэ журмын гол зорилго оршино.

Хоёр. Үйлчлүүлэгч зурагтай харьцах

- 2.1. Үйлчлүүлэгч нууцын зэрэглэлтэй зурагтай танилцахдаа биеийн байцаалт болон бичиг баримтыг бүртгүүлж үйлчлүүлнэ.
- 2.2. Нууцын зэрэглэлтэй зурагтай харьцахдаа 1 үйлчлүүлэгч 1 удаа 5-аас дээшгүй зургийг 15 минутад үзнэ.
- 2.3. Нууцын зэрэглэлтэй зурагтай харьцахдаа зураг дээр ямар нэг тэмдэглэгээ хийхийг хатуу хориглоно.

- 2.4. Нууцын өрөөнд цүнх болон гадуур хувцастай орохыг хориглоно. Зөвхөн үзэг, харандаа, цаастай орно.
- 2.5. Нууцын өрөөнөөс өөр өрөөнд нууцын зэрэглэлтэй зургийг дамжуулан үзэхийг хориглоно.
- 2.6. Үйлчлүүлэгч нууцын зэрэглэлтэй зурагтай танилцах үедээ өрөөнөөс гарах буюу бусдад саад болохыг хориглоно.
- 2.7. Нууцын өрөөнд нэг ээлжинд 3 хүртэлх этгээд үйлчлүүлнэ.

### Гурав. Ажиллагсад зурагтай харьцах

- 3.1. АМХЭГ-ын нууцын зэрэглэлтэй зурагтай харьцах зөвшөөрөлтэй мэргэжилтнүүд нууцын зэрэглэлтэй зурагтай харьцахдаа үйлчилгээний өдрөөс бусад өдөр зурагтай танилцана.
- 3.2. Нууцын зэрэглэлтэй зурагтай харьцдаг мэргэжилтнүүд нууцын эрхлэгчид бүртгүүлж зураг авна.
- 3.3. Байр зүйн зургийг үрэгдүүлэх, бусдад дамжуулах, гэмтээх, хуулбарлах өрөөнөөс авч гарахыг хатуу хориглоно.
- 3.4. Байр зүйн зураг дээрх тэмдэглэгээг зөвхөн зураг зүйн мэргэжилтнүүд хийнэ.
- 3.5. ГУУКА-ны Зураг зүйн багийн мэргэжилтнүүд ажлын шаардлагатай зургаа нууцын эрхлэгчид бүртгүүлж, ажил тарахаас 15 минутын өмнө буцааж хүлээлгэж өгнө.
- 3.6. АМХЭГ-ын ажиллагсад нь үйлчлүүлэгчдэд зураг үзүүлэхийг хатуу хориглоно.
- 3.7. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд нууцын зэрэглэлтэй зургийг АМХЭГ-ын дарга болон ГУУКА-ны даргын цохолтоор эрх бүхий хүмүүст үзүүлнэ.
- 3.8. Энэхүү журмыг зөрчсөн ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд зураг зүйн бүртгэлтэй танилцах үйлчилгээг хийхгүй болон холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.